БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
# БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
# МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ

201 9 оны 08 дугаар сарын 16 өдөр | Дугаар 1277/2019

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс:

| | |
|---|---|
| **Барилга, байгууламжийн байршил, нэр, зориулалт:** | Өмнөговь аймгийн Номгон сумын 6-р багийн нутаг дэвсгэрт баригдах "15 ортой эмнэлгийн барилга"-ын холболтын ажлын зураг төсөл, төсөв<br>**ШИФР: БДК-А3-05/2019** |
| **Хүчин чадал:** | **Барилгын хэмжээ:** Тэнхлэгээрээ 21.0 м х 30.0 м, 16.0 м х 6.0 м хэмжээтэй 2 блок,<br>**Давхрын тоо:** ± 0.00 түвшнээс доош зоорийн давхаргүй, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар,<br>**Барилгын ажлын талбай:** $S_{аж}$=772.88 м$^2$ |
| **Захиалагч:** | Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар |
| **Санхүүжилтийн эх үүсвэр:** | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар |
| **Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:** | "Бэст дизайн констракшн" ХХК |
| **Регистрийн дугаар:** | РД: 6062482 |
| **Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:** | 2021.05.10 |
| **Ажлын төрөл:** | 1.2.2, 1.2.4, 1.2.5 заалтын дагуу |

**Зураг төсөл боловсруулах үндэслэл:**

| | |
|---|---|
| Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо: | Өмнөговь аймгийн Номгон сумын Засаг даргын 2010 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/54 тоот захирамж,<br>Газар эзэмших эрхийн 0173503, 0173502 дугаартай гэрчилгээ. |
| Архитектур төлөвлөлтийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Өмнөговь аймгийн Ерөнхий архитекторын баталсан 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 65 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар |
| Зургийн даалгавар, гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын даргын баталсан 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн ЗТ-43/2018 дугаартай зураг төсөл, төсөв боловсруулах даалгавар,<br>"Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар", "Бэст дизайн констракшн" ХХК нарын хооронд байгуулсан 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн ӨМАОНӨГ/201810258 дугаартай зураг төсөл, төсөв боловсруулах гэрээ |

**Техникийн нөхцөл олгогдсон байдал:**

| Техникийн нөхцөлүүд: | Олгосон байгууллага: | Дугаар, огноо | Хүчинтэй байх хугацаа: |
|---|---|---|---|
| Дулаан хангамж: | | | |
| Ус хангамж, ариутгах татуурга: | "Номдизель" ОНӨААТҮГ | 2019.03.19-ний № 10 | - |
| Цахилгаан хангамж: | "ӨБЦТС" ТӨХК | 2019.05.28-ны № 19/2019 | 1 жил |
| Холбоо, дохиолол: | "МХС" ХХК Өмнөговь аймгийн газар | 2019.03.28-ны № ТН-В16/2019 | 1 жил |

**Зөвшөөрөлцсөн байгууллагууд:**

| | |
|---|---|
| Өмнөговь аймгийн Ерөнхий архитектор | Ц.Золбоо |
| Өмнөговь аймгийн Газрын харилцаа, Барилга, Хот байгуулалтын газрын дарга | Ю.Энхтуяа |
| Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын дарга | Л.Баярсайхан |
| Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга | Д.Мөнхтулга |
| "Номдизель" ОНӨААТҮГ-ын захирал | Н.Наранхүү |
| "ӨБЦТС" ТӨХК-ийн дэд захирал бөгөөд ерөнхий инженер | Т.Гантөмөр |
| "МХС" ХХК-ийн Өмнөговь аймгийн газрын ерөнхий инженер | З.Мөнхчимэг |

**Барилга, байгууламжийн зураг төслийн бүрэлдэхүүн:**

| Зураг төслийн иж бүрдэл: | Зураг төсөл гүйцэтгэсэн байгууллагын нэр: | Магадлал хийсэн экспертийн нэр: |
|---|---|---|
| Ерөнхий төлөвлөгөө, өндөржилт, барилга архитектур: | "Бэст дизайн констракшн" ХХК | Ц.Батбаяр |
| Барилга бүтээц: | "Бэст дизайн констракшн" ХХК | Ц.Бат-Очир |
| Дулаан хангамж: | "Бэст дизайн констракшн" ХХК | Б.Бат-Эрдэнэ |
| Гадна, дотор ус хангамж, ариутгах татуурга: | "Бэст дизайн констракшн" ХХК | Д.Дагвасүрэн |
| Цахилгаан хангамж: | "Бэст дизайн констракшн" ХХК | Г.Гантуяа |
| Гадна, дотор холбоо, дохиолол: | "Бэст дизайн констракшн" ХХК | Д.Доржсүрэн |
| Төсөв: | "Тэмжин" ХХК | С.Нямаа |
| Инженер геологи: | "Гурван тэс" ХХК /Архив № 18/19/ | Ц.Оюун |

**Нэгтгэсэн дүгнэлт:** */Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/*

**Барилга байгууламжийн техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;**

**Барилга, байгууламж баригдах газрын байгаль, цаг уурын ерөнхий өгөгдөл:**
Гадна агаарын хэм: -25.5 °C
Цасны ачаалал: 30 кг/м$^2$
Салхины ачаалал: 47 кг/м$^2$
Газар хөдлөлийн балл: 9 балл

**Барилгын суурь суух буурь хөрс:**
Суурь суух буурь хөрс нь орчин үеийн ба дээд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, улаан хүрэн өнгөтэй, хатуу консистенцитэй хайргархаг шаваранцар ул хөрс байна.
Хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн -2.80 м,
Хөрсний ус илрээгүй байна.

**Буурь хөрсний механик шинж чанарын үзүүлэлт:**
Зууралтын хүч: $C_н$=36.0 кПа
Дотоод үрэлтийн өнцөг: $Φ_н$=31°
Хэв гажилтын модуль: $E_н$=30 мПа
Тооцооны эсэргүүцэл: $R_o$=400 кПа
Газар шорооны ажлын зэрэг: III
Хөрсний овойлтын зэрэг: Улирлын хөлдөлтийн бүсэд дунд зэргийн овойлттой хөрсөнд нормчлогдоно.

**Барилга, байгууламжийн төлөвлөлт:**
"Барилгын хөгжлийн төв"-ийн 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн ЕД-1535/2018 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан Өмнөговь аймгийн Манлай сумын 4-р багийн нутаг дэвсгэр дэх "15 ортой эмнэлгийн барилга"-ын ажлын зураг төслийг суурийн холболтоор Өмнөговь аймгийн Номгон сумын 6-р багийн

нутаг дэвсгэрт байршуулахаар төлөвлөж зураг төслийг боловсруулсан байна.

Гадна довжооны хэсэгт "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт" /БД 31-112-11/-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж ариун цэврийн өрөө болон налуу зам төлөвлөсөн байна.

**1-р давхарт:** Гонх, хүлээн авах өрөө, түргэн тусламжийн өрөө, ажилчдын хувцас солих өрөө, сургалт, хурлын өрөө, цахилгааны өрөө, шинжилгээ авах өрөө, рентгений өрөө, зураг авах өрөө, эмчийн өрөөнүүд, эмийн сан, эм хадгалах өрөө, вакцины өрөө, гал тогоо, хүнсний агуулах, узелийн өрөө, ариун цэврийн өрөө, халдвартын өрөө, эмэгтэйчүүдийн үзлэгийн өрөө, холбооны өрөө, бохир хүлээн авах өрөө, угаалгын өрөө, бохир багаж хүлээн авах өрөө, ариутгах өрөө, цэвэр багаж хадгалах өрөө, архивын өрөөг,

**2-р давхарт:** Нярвын өрөө, эмчийн өрөө, эрхлэгчийн өрөө, шүдний эмчийн өрөө, физик эмчилгээний өрөө, чийрэгжүүлэх танхим, ариун цэврийн өрөө, хэвтэн эмчлүүлэх өрөө, шүршүүрийн өрөө, төрөх өрөө, мэс заслын өмнөх өрөө, мэс заслын өрөө, эрчимт эмчилгээний өрөө, тагт, террас байхаар тус тус төлөвлөсөн байна.

**Үндсэн бүтээц нь:**

**Суурь:** Цутгамал төмөр бетон баганан суурьтай,

**Даацын үндсэн бүтээц:** Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй,

**Гадна хана:** 250 мм-ийн хөнгөн блокон өрөгт ханатай, 150 мм-ийн зузаантай эрдэс хөвөн хавтан дулаалгатай,

**Хучилт:** Цутгамал төмөр бетон хучилттай

**Дээвэр:** Хавтгай дээвэртэй байхаар тус тус төлөвлөсөн байна.

**Гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлт:**

**Гадна дулаан хангамж:**

Төлөвлөж буй барилгын сууринд орсон 2Ф100 мм-ийн шугамыг зөөж, дулааны ДХ-2 худгийн 2Ф100 мм-ийн голчтой шугамаас 2Ф65 мм-ийн голчтой ган хоолойгоор оглолгоо авч, ул нэвтрэх цутгамал төмөр бетон сувагт, бетон дэр дээр гулсах тулгууртайгаар угсарч төлөвлөж буй барилгыг дулаанаар хангахаар төлөвлөсөн байна.

**Ус хангамж, ариутгах татуурга:**

Цэвэр ус хангамжийг Ф50 мм-ийн голчтой цайрдсан ган хоолойгоор дулааны шугамтай хамт нэг сувагт угсарч холбохоор төлөвлөж, барилгаас гарах бохир усыг одоо байгаа бохир усны БУХ-4 худагт Ф150 мм-ийн голчтой хуванцар хоолойгоор холбож зайлуулахаар төлөвлөсөн байна.

**Гадна цахилгаан хангамж:**

Цахилгаан хангамжийг техникийн нөхцөлийн дагуу Номгон сумын 15 кВ-ын ЦДАШ-ын тулгуур №879-ийг салбарлалтын анкер болгон хуурай салгуур тоноглож, 15 кВ-ын төмөр бетон тулгууртай АС-50 дамжуулагч утастай цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр татаж, 15/0.4 кВ-ын 160 кВа чадалтай иж бүрэн дэд өртөө шинээр

| | |
|---|---|
| | угсарч 0.4 кВ-ын гаргалгаанаас АВВБ-ШВ маягийн 3х95+1х50 мм² хөндлөн огтлолтой кабель шугамаар төлөвлөж буй барилгын ерөнхий оролтын самбарыг тэжээхээр төлөвлөсөн байна.<br>**Гадна холбоо, дохиолол:**<br>Холбоо хангамжийг аймгийн холбооны барилгаас 12 корын шилэн кабелийг цэнэглэн авч одоо байгаа болон шинээр хийх сувагчлалаар үргэлжлүүлэн татаж төлөвлөж буй барилгын төгсгөлийн төхөөрөмжид холбохоор төлөвлөсөн байна. |
| **Зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх;** | **Чиглэл тус бүрийн орон тооны бус экспертийн саналыг зураг төсөлд тусгасан байдал:**<br>Экспертүүдийн өгсөн үүрэг даалгаврын дагуу зураг төсөлд засвар өөрчлөлтүүдийг хийсэн байна. |
| **Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;** | **Хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан байдал:**<br>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эмнэлгийн барилга баригдсанаар тухайн орон нутгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөц болон эмнэлгийн үйлчилгээний хүчин чадал нэмэгдэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах нөхцөл бүрдэх юм. |

**Өмнөговь аймаг, Номгон сумын 6-р багийн нутаг дэвсгэрт баригдах "15 ортой эмнэлгийн барилга"-ын төсөвт өртгийн нэгдсэн товчоо**

Барилга угсралтын ажлын

| № | Тодорхойлолт | Төсөвт өртөг /төг/ | Хүчин чадал | Нэгж өртөг /төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | <u>а/. Эмнэлгийн барилга угсралтын ажил:</u> | | | |
| ББ | Барилга: Тэнхлэгээрээ 21.0 м х 30.0 м, 16.0 м х 6.0 м хэмжээтэй, 2 блок, Давхрын тоо: Зоорьгүй, 2 давхар | 1,020,015,778.0 | 1,107.76 | 920,791.3 |
| ХАС | Талбайн хэмжээ: 1107.76 м² Суурь: Цутгамал төмөр бетон баганан суурьтай, | 85,774,429.0 | 1,107.76 | 77,430.5 |
| ЦБУ | Үндсэн хийц: Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй, | 28,865,905.0 | 1,107.76 | 26,057.9 |
| ДГ-ХТ | Гадна хана: 250 мм-ийн хөнгөн блокон өрөгт ханатай, 150 мм-ийн эрдэс хөвөн хавтан дулаалга, Хучилт: Цутгамал төмөр бетон хучилт | 66,116,651.0 | 1,107.76 | 59,685.0 |
| ХД | Дээвэр: Хавтгай дээвэртэй | 33,138,977.0 | 1,107.76 | 29,915.3 |
| | **Хэсгийн дүн:** | **1,233,911,740.0** | **1,107.76** | **1,113,880.0** |
| 2 | <u>б/. Туслах барилга байгууламжийн барилга угсралтын ажил:</u> | | | |
| ТБ | Хог хаягдлын байрны барилга Тоосгон өрөгт бүтээцтэй, цутгамал төмөр бетон хучилттай, зоорьгүй 1 | 20,853,166.0 | 24.0 | 868,881.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | давхар | | | |
| | Шарил хадгалах байрны барилга Тоосгон өрөгт бүтээцтэй, цутгамал төмөр бетон хучилттай, зоорьгүй 1 давхар | 39,399,267.0 | 36.70 | 1,073,549.5 |
| | **Хэсгийн дүн:** | **60,252,433.0** | | |
| 3 | <u>в/. Гадна инженерийн шугам сүлжээний ажил:</u> | | | |
| ГД | Гадна дулаан, цэвэр ус: Ф100мм-ийн хоолой 185м, Ф70мм-ийн хоолой 12м, Ф50мм-ийн хоолой 12м | 87,388,946.0 | 209.0 | 418,128.9 |
| | Гадна ус хангамж /м/: Дулааны сувагт цайрдсан ган яндан Ф57 мм | 3,757,942.0 | 91.0 | 41,296.1 |
| УХАТ | Ариутгах татуургын шугам /м/: Ф160 мм, Ф110 мм-ийн дулаалгатай хуванцар хоолой | 13,550,920.0 | 86.7 | 156,296.7 |
| | Гадна цахилгаан /м/: 0.4 кВ-ын кабель шугам АВВБ-3x95+1x70 мм$^2$ | 22,210,194.0 | 515.0 | 43,126.6 |
| | Гадна цахилгаан /м/: 15 кВ-ын ЦДАШ АС-50 | 49,271,987.2 | 2,790.0 | 17,660.2 |
| ГЦ | Гадна дэд өртөө /ш/: 15/0.4 кВ-ын агаарын дэд өртөө АТП-160/15 | 25,858,529.0 | 1.0 | 25,858,529.0 |
| | Гадна гэрэлтүүлгийн тэжээл /м/: 0.4 кВ-ын кабель 4x16 мм$^2$ | 12,086,713.0 | 344.0 | 35,135.8 |
| | Гадна гэрэлтүүлэг /ш/: Нэг толгойтой төмөр шон, явган гэрэл | 5,685,982.0 | 12.0 | 473,831.8 |
| ГХ | Гадна холбоо /м/: Сувагчлалын 12 корын шилэн кабель | 13,620,884.0 | 220.0 | 61,913.1 |
| | **Хэсгийн дүн:** | **233,432,097.2** | | |
| 4 | <u>г/. Гадна тохижилтын ажил:</u> | | | |
| ГТ | Явган зам, талбай /м$^2$/: Өнгөт хавтан хучилттай | 33,835,889.0 | 1,125.3 | 30,068.3 |
| ГТ | Авто зогсоол /м$^2$/: Асфальт бетон хучилттай | 29,191,987.0 | 460.9 | 63,336.9 |
| ГТ | Ногоон байгууламж /м$^2$/: Зүлэгжүүлэлт | 3,861,942.0 | 164.9 | 23,419.9 |
| ГТ | Сандал, хогийн сав, сүүдрэвч | 4,700,201.0 | 14.0 | 335,728.6 |
| ГТ | Гадна хашаа /м$^2$/: | 39,251,404.0 | 441.0 | 89,005.5 |
| | **Хэсгийн дүн:** | **110,841,423.0** | | |
| 5 | д/. Тоног төхөөрөмж: | | | |
| ТТ | Тоног төхөөрөмж /ш/: 15/0.4 кВ-ын 160 кВа чадалтай трансформатор | 12,439,440.0 | 1.0 | 12,439,440.0 |
| | **Хэсгийн дүн:** | **12,439,440.0** | | |
| | **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | | **1,650,877,133.2** | |

Төсөв:

Эксперт нь: Өмнөговь аймгийн Номгон сумын 6-р багийн нутаг дэвсгэрт баригдах "15 ортой эмнэлгийн барилга"-ын ажлын нийт төсөвт өртгийг **1 650 877 133** /нэг тэрбум зургаан зуун тавин сая найман зуун далан долоон мянга нэг зуун гучин гурав/ төгрөгөөр хянажээ.

**"Барилгын тухай" Монгол улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх;", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.", 39.5-д "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".**

Тухайн зураг төсөл нь Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 30/49 дугаартай дүгнэлт, Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 16/03/032/98 дугаартай дүгнэлтээр тус тус хянагдсан байна.

Өмнөговь аймгийн Номгон сумын 6-р багийн нутаг дэвсгэрт баригдах "15 ортой эмнэлгийн барилга"-ын холболтын ажлын зураг төсөл, төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНбД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНбД 81-95-12/, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 2-2023 тоот албан бичгийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн дүгнэлт бичсэн болно.

Нэгтгэсэн дүгнэлт нь экспертүүдийн **17** хуудас магадлалын дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН

| | |
|---|---|
| БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ | Б.ГАНБОЛД |
| НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА | Д.АЛТАНХУЯГ |
| БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН | М.МАРГАД-ЭРДЭНЭ |

Зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР **/Барилга архитектур:/**
*15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв*

2019 оны 07 сарын 04 өдөр

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Обьектын нэр | 15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв |
| 2 | Объектын байршил, хүчин чадал | Өмнөговь аймаг, Номгон сум, баг |
| 3 | Зураг төслийн байгууллага | "Бэст дизайн констракшн" ХХК |
| 4 | Зургийн шифр | шифр: Б.Д.К-АЗ-05/2019 |
| 5 | Хуудасны тоо | ЕТ 5 хуудас, БА 25 хуудас, ТХ 2 хуудас |
| **6. Дүгнэлтийн товч утга:** /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/ | | |
| 1 | 7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал; | Өмнөговь аймгийн Номгон сумын Засаг даргын 2010-07-06-ны дугаар 54 тоот захирамжтай. Өмнөговь аймгийн Ерөнхий архитектор Ц.Золбоогийн баталсан загвар зурагтай.<br>гадна агаарын температур -21.3С<br>цасны ачаалал 70кг/м2<br>салхины ачаалал 30кг/м2<br>эдэлгээний зэрэг II<br>гал тэсвэрлэлтийн зэрэг II<br>газар чичирхийлэл 6 балл |
| 2 | 7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтэц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх; | Тус эмнэлгийн барилга нь 30.0м х 38.4м хэмжээтэй, төмөрбетон каркасан бүтээцтэй, зоорьгүй 2 давхар барилга болно. 1-р давхар нь 2 блок бөгөөд үндсэн блоконд хүлээн авах, яаралтай тусламжын, үзлэгийн, эмчийн, вакцины, рентгений, халдвартын өрөөнүүд,цахилгааны өрөө, гал тогоо, ариун цэврийн өрөөнүүд, туслах блоконд 2 машины гарааш, ариутгалын, угаалгын өрөөнүүд, 2-р давхарт эрхлэгчийн, эмчийн, нярав, нябогийн, сувилагчийн, хэвтэн эмчлүүлэгчдийн, мэс заслын, төрөхийн өмнөх ба дараах, төрөх өрөөнүүд, ариун цэврийн өрөө төлөвлөсөн. |
| 3 | 7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт; | Өмнөговь аймгийн Номгон сумын төвийн шинэчлэсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан одоо байгаа эмнэлгийн дэргэд төлөвлөсөн байна. |
| 4 | 7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал; | |
| 5 | 7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал; | |
| 6 | 7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал; | Гол орцуудад тэргэнцэртэй иргэдэд зориулсан налуу зам тусгаж өгсөн. |
| 7 | 7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх; | |
| 8 | 7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл; | |
| 9 | 7.5.9. барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, ээлжүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал; | Уг эмнэлгийн гадна төрх нь тухайн сумын төвд өнгө нэмэхүйц шийдэлтэй болсон гэж үзэж болно<br>К1 = 0.69 К2 = 3.05 |
| 10 | 7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал. | |
| 11 | 7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана. | Холбогдох норм, дүрэм /БД31-115-12, БНбД 31-03-03, ЦАЦУД-83/ болон зургийн даалгаврын дагуу гүйцэтгэсэн, 2018 онд БХтөвийн магадлалаар орсон энэ ажлын зургаар угсралтын ажил гүйцэтгэх бүрэн боломжтой болно. |

Дүгнэлт бичсэн
Эксперт № 1-5 Ц.Батбаяр ……………………/

BATBAYAR consulting ARCHITECT

2019 оны 07 сарын 04 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР **/Барилга бүтээц:/**
*15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв*

2019 оны 07 сарын 05 өдөр

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Обьектын нэр | 15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв |
| 2 | Объектын байршил, хүчин чадал | Өмнөговь аймаг, Номгон сум, баг |
| 3 | Зураг төслийн байгууллага | "Бэст дизайн констракшн" ХХК |
| 4 | Зургийн шифр | BDC-A3-08-2018 |
| 5 | Хуудасны тоо | ББ 35 хуудас |
| **6. Дүгнэлтийн товч утга:** /Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоос/ | | |
| 1 | 7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал; | Барилга бүтээцийн зураг төслийг архитектур төлөвлөлт, инженер геологи, дэвсгэр зураг өндөржилтийг үндэслэн боловсруулсан. Цаг уурын ерөнхий өгөгдлүүд:<br>Гадна агаарын тооцооны температур -20.7c<br>Цасны ачаалал 30кг/м2<br>Салхины хурд /жилийн дундаж/ 47кг/м2<br>Газар хөдлөлийн балл 9 балл |
| 2 | 7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх; | Барилга нь тэнхлэгээрээ 37.5x30.0м хэмжээтэй зоорьгүй 2 давхар цутгамал төмөр бетон каркасан барилга байхаар төлөвлөгдсөн. |

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 3 | 7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт; | Барилгын инженер геологийн "Гурван тэс" ХХК-д боловсруулсан дүгнэлтээр суурь суух буурь хөрс нь улаан хүрэн өнгөтэй, орчин үе дээд дөрөвдөгчийн настай, делюви пролювийн гаралтай, хатуу консистенцитэй хайргархаг шаваранцар хөрс болно.<br>Барилга бүтээцийн тооцоог Lira 9.6 (R9) программ дээр хийсэн. |
| 4 | 7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал; | |
| 5 | 7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал; | |
| 6 | 7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал; | |
| 7 | 7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх; | |
| 8 | 7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл; | |
| 9 | 7.5.9. барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, ээлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал; | |
| 10 | 7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал. | |

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 11 | 7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана | |

Дүгнэлт бичсэн

Эксперт № 2-6 Ц.БатОчир /................................/

2019 оны 07 сарын 05 өдөр

Зураг теслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР
*15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв*

2019 оны 07 сарын 05 өдөр

| Д/д | **Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил** | **Биелэлт** |
|---|---|---|
| 1 | Барилгын зураг төсөл боловсруулах стандартын дагуу барилга бүтээцийн нүүр хуудсыг хийж баталгаажуулах. | Нүүр хуудсыг стандартын дагуу болголоо. |
| 2 | ББ-1 маркийн хуудсанд тайлбар бичигт барилгын тооцооны схем үзүүлэх. | ББ-1 хуудсанд тооцооны схемийг үзүүллээ. |

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 2-6 ............................................... / Ц.БатОчир/

..... оны ..... сарын ..... өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн ............................................................ /Г. Ган-Эрдэнэ/

2019 оны 07 сарын 07 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР **/Гадна дулаан:/**
*15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв*

2019 оны 07 сарын 05 өдөр

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Обьектын нэр | 15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв |
| 2 | Объектын байршил, хүчин чадал | Өмнөговь аймаг, Номгон сум, баг |
| 3 | Зураг төслийн байгууллага | "Бэст дизайн констракшн" ХХК |
| 4 | Зургийн шифр | BDC-A3-04/2019 |
| 5 | Хуудасны тоо | 8 |
| **6. Дүгнэлтийн товч утга:** /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/ | | |
| 1 | 7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал; | "Номдизель" ОНӨААТҮГ-ын 2019 оны 3-р сарын 19-ны №10 тоот дулааны шугаманд холбох тухай албан тоот. Холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн. Гадна агаарын тооцооны температур t=-23.8°С |
| 2 | 7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх; | БНбД41-02-13, БНбД41-04-13 зэрэг норм, нормативын баримт бичгийн дагуу зохиогдсон. |
| 3 | 7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт; | инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо байхгүй |
| 4 | 7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал; | БНбД41-04-13 нормын дагуу дулааны эрчим хүчийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн. |
| 5 | 7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал; | - |
| 6 | 7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал; | хамааралгүй |
| 7 | 7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх; | хамааралгүй |
| 8 | 7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл; | Төлөвлөлт оновчтой. |
| 9 | 7.5.9. барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, ээлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал; | БА-ын хэсгээс үзнэ |
| 10 | 7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал. | Тусгаагүй |
| 11 | 7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашиг, мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана. | ГД-ы ажлын зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх саналгүй. |

Дүгнэлт бичсэн
Эксперт № 3-9 Б.БатЭрдэнэ /........................../

2019 оны 07 сарын 05 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР **/Гадна ус хангамж, ариутгах татуурга:/**
*15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв*

2019 оны 07 сарын 04 өдөр

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Обьектын нэр | 15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв |
| 2 | Обьектын байршил, хүчин чадал | Өмнөговь аймаг, Номгон сум, баг |
| 3 | Зураг төслийн байгууллага | "Бэст дизайн констракшн" ХХК |
| 4 | Зургийн шифр | БДК-А3-04/2019 |
| 5 | Хуудасны тоо | 6+7 |
| **6. Дүгнэлтийн товч утга:** /Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоос/ | | |
| 1 | 7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал; | ЕТ, 10-тоот техникийн нөхцлийн дагуу зургийг боловсруулсан. |
| 2 | 7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх; | 7 метрт хөрсний ус илрээгүй овоолт үүсгэхгүй хөлдөлтийн гүн 1,0 м газар хөдлөл9 балл |
| 3 | 7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт; | |
| 4 | 7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал; | |
| 5 | 7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал; | |
| 6 | 7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал; | |
| 7 | 7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх; | |
| 8 | 7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл; | |
| 9 | 7.5.9. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, ээлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал; | |
| 10 | 7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал. | |
| 11 | 7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлгээ өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана. | хавсралтаас үзнэ үү |

Дүгнэлт бичсэн
Эксперт № 6-11 Д.Дагвасүрэн /............................/

2019 оны 07 сарын 04 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР
*15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв*

2019 оны 07 сарын 04 өдөр

| Д/д | Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил | Биелэлт |
|---|---|---|
| 1 | Дотор шугамд насос төлөвлөх шаардлатай эсэхийг дахин хянаж үзэх. | Насос төлөвлөсөн |
| 2 | Бохир усны гаргалгаа гадна шугамтайгаа холбогдохгүй байна засах. | Бохир усны шугамын гаргалгаа дотор зурагтайгаа холбогдохгүй буруу байсныг зөв болгож засав. |
| 3 | Дулааны шугамын угсралтын тоймыг хуулбарлан тавьсан нь ойлгомжгүй байна. Ядаж усны шугамын диаметр байхгүй байна УХАТ-4-р хуудас | Угсралтын тоймд цэвэр усны шугамын диаметр тавьж өгөв. |
| 4 | Зургуудад гарын үсэг зурагдаагүй байна гарын үсэг зуралгүй хяналтанд оруулж байгаа анхаарал татаж байна. | Гарын үсэг зурав |

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 6-11 .............................. /Д.Дагвасүрэн/

19 оны 07 сарын 05 өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн .............................. /Л.Сэлэнгэ/

2019 оны 07 сарын 05 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР **/Гадна цахилгаан:/**
*15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв*

2019 оны 07 сарын 10 өдөр

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Обьектын нэр | 15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв |
| 2 | Объектын байршил, хүчин чадал | Өмнөговь аймаг, Номгон сум, баг |
| 3 | Зураг төслийн байгууллага | "Бэст дизайн констракшн" ХХК |
| 4 | Зургийн шифр | Б.Д.К-А3-04/2019 |
| 5 | Хуудасны тоо | ГЦ-22х, ГЦ-04х, ГЦ-8х,ГЦ-34х |
| **6. Дүгнэлтийн товч утга:** /Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоос/ | | |
| 1 | 7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал; | Гадна цахилгаан хангамжийн зургийг ӨБЦТС ТӨХК-ийн олгосон №16/2019 тоот техникийн нөхцөлийг үндэслэн боловсруулжээ.<br>Гүйцэтгэсэн инженер Б.Төрболд, шалгасан Б.Дашлхам.<br>ӨБЦТС ТӨХК-тай зөвшилцсөн. |

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 2 | 7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх; | Цахилгаан хангамжийн ажлын зургийг:<br>1.Эмнэлгийн барилга БД 31-115-12<br>Цахилгаан байгууламжийн дүрэм. БД 43-101-03<br>2. Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмж төлөвлөх ба угсрах БД 43-102-07<br>3. Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг БНбД 23-0208<br>4. Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар БД 43-103-08<br>5. Цахилгаан тоног төхөөрөмж болон гүйдэл дамжуулагчийн таних тэмдэг MNS 3757-16:2015<br>6. Цахилгаан техникийн ажил БНбД 3.05.06-90 дүрмийн дагуу хийж гүйцэтгэжээ. |
| 3 | 7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт; | Газардуулгын тооцоог инженер геологийн "БАРНАБ" ХХК-д хийгдсэн архив №57/19 шифр бүхий инженер геологич Б.Буянхишигийн хийсэн инженер геологийн дүгнэлтийг үндэслэн хийжээ. |
| 4 | 7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал; | Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүчний хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна. |
| 5 | 7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал; | Монгол улсад мөрдөж байгаа холбогдох норм дүрмийн дагуу зураг төслийг боловсруулсан байна. |
| 6 | 7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал; | Барилга архитектурын зурагт хамаарна. |
| 7 | 7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх; | Барилга архитектурын зурагт хамаарна. |

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 8 | 7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуухь төлөвлөлтийн оновчтой шийдэл; | Тухайн барилгын цахилгааны зураг нь инженерийн шугам сүлжээний уртын дагуухь төлөвлөлтийн оновчтой шийдэлтэй уялдсан байна. |
| 9 | 7.5.9. барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, ээлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал; | Барилга архитектурын зурагт хамаарна. |
| 10 | 7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал. | |
| 11 | 7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана. | Зураг төслийг холбогдох норм, дүрэм стандартын дагуу төлөвлөх |

Дүгнэлт бичсэн

Эксперт № 5-19 Г.Гантуяа /............................../

2019 оны 07 сарын 10 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР
*15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв*

2019 оны 07 сарын 10 өдөр

| Д/д | Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил | Биелэлт |
|---|---|---|
| 1 | 15кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын зурагт:<br>1.Материалын түүвэрт тулгуурын тоо-20ш, Зургаар түүхэд 19ш байна.<br>2. Зурагт шугамын алгасалт 38-70м гэж тусгасан, тооцож үзэхэд 1009м байгаа ч материалын түүвэрт 9300/3=3100м байгааг хянах<br>3. Газардуулгын ажлын тоо хэмжээг хянах. 15кВ-ын бүх тулгуурт газардуулга хийхээр тусгасан ч газардуулгын шуудуу ухах-1,71м3, булах-1,03м3 байна.<br>4. Шувуу үргээгч-1ш л байх уу? | 1.Материалын түүвэрт тулгуурын тоог 19 болгон засав. 2. Агаарын шугамын тоо хэмжээг засав. 3.Газардуулгын ажлын тоо хэмжээг хянав, 4. Шувуу үргээгчийн тоог засав. |
| 2 | АТП-160кВА дэд өртөөний зурагт:<br>1. Материалын түүвэрт төмөр бетон шон-0ш байгааг засах | 1. Материалын түүвэрт төмөр бетон шон-2ш болгон засав. |

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 5-19
........................................ /Г.Гантуяа/
2019 оны 07 сарын 19 өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн ........Б.Төрболд........ /
Б.Төрболд/

2019 оны 07 сарын 19 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР **/Гадна холбоо, дохиолол:/**
*15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв*

2019 оны 07 сарын 04 өдөр

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Обьектын нэр | 15 ортой эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв |
| 2 | Обьектын байршил, хүчин чадал | Өмнөговь аймаг, Номгон сум, баг |
| 3 | Зураг төслийн байгууллага | "Бэст дизайн констракшн" ХХК |
| 4 | Зургийн шифр | ГХ ТГ- ЕСА-27/2019 ХД ЕГ BDC - 02/2018 ТГ - ? |
| 5 | Хуудасны тоо | ГХ - 3 хуудас ХД- 10 хуудас |
| **6. Дүгнэлтийн товч утга:** /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоос/ | | |
| 1 | 7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал; | **ГАДНА ХОЛБОО:**<br>МХС ТӨХХК-ийн Өмнөговь аймгийн холбооны газартай зураг төслийг зөвшилцсөн баталгаажуулсан , харин орон нутгийн бусад инженерийн шугам сүлжээний ашиглалтын байгууллагууд ба ГХБХБ-ын газар ( алба )-тай зураг төслийг зөвшилцөөгүй байгааг нөхөж хийх шаардлагатай.<br>**ХОЛБОО ДОХИОЛОЛ:**<br>ХД-ийн зураг төслийг барилгын БА ,ББ ба инженерийн бусад шугам сүлжээний зураг төсөл зохиогч нартай зөвшилцсөн байна |
| 2 | 7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх; | **1. Гадна холбоо / телефон холбоо /**<br>Зураг төслийн ажлыг "Холбооны кабель шугамын ажлын зураг" MNS 6305:2012 стандартад тавигдаг шаардлага ,МХС ТӨХХК-ийн Өмнөговь аймгийн холбооны газрын 2019.03.28- оны ТН- В16/2019 тоот техникийн нөхцлийн дагуу төлөвлөсөн байна.<br>**2. Холбоо дохиолол:**<br>Зураг төслийн ажлыг<br>- "Барилгын зураг, холбоо,мэдээлэл, дохиоллын кабель шугам ба тоног төхөөрөмжийн тэмдэглэгээ" MNS 5532:2016<br>- "Барилга байгууламжийн мэдээлэл, холбоо ба дохиоллын ажлын зураг боловсруулах"<br>MNS 6586:2016, стандарт ,<br>- "Барилгын дотор холбоо , дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт. MNS 5471:2005,<br>-Барилга, байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл БНбД 21-04-05<br>- Барилга , орон сууц , гудамж талбайд тавих хяналтын камерын шаардлага MNS 6423:2014 зэрэгт тавигддаг шаардлага, техникийн нөхцлийн дагуу төлөвлөсөн байна |
| 3 | 7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт; | хамааралгүй |

| Д/д | Утга | Тайлбар |
| --- | --- | --- |
| 4 | 7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал; | хамааралгүй |
| 5 | 7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал; | хамааралгүй |
| 6 | 7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал; | хамааралгүй |
| 7 | 7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх; | хамааралгүй |
| 8 | 7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл; | ГАДНА ХОЛБОО:<br>Холбооны сүлжээний трассын төлөвлөлтийн шийдэл боломжийн харин дулааны шугамтай огтлолцсон цэгт шугамын хамгаалалт төлөвлөөгүй огтлолцолын хэсэгт босоо зүсэлтын зураг гаргаагүй |
| 9 | 7.5.9. барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, ээлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал; | хамааралгүй |
| 10 | 7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал. | Угсралтын явцад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангах талаар зургийн тайлбарт тусгасан байна |
| 11 | 7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана. | **1. ГАДНА ХОЛБОО**<br>**ДҮГНЭЛТ** :<br>МУ-д мөрдөгдөж байгаа гадна холбооны зураг төслийг төлөвлөх стандарт , нормыг баримтлан төлөвлөсөн байна.<br>Зураг төсөлд магадлал хийх явцад ШХ1 ба ШХ 2 худгуудын хоорондох нисэлтэнд холбооны сүлжээ дулааны шугамтай огтлолож байгаа цэгт холбооны сүлжээнд хамгаалалт төлөвлөх, огтлолцолын босоо зүсэлтйн зураг хийлгэж төсөлд хавсаргуулав. Зураг төслийг орон нутгийн ИШСАБ-ууд ба газрын албатай тохиролцон баталгаажуулах шаардлагатай<br>**Цаашид анхаарах:**<br>1.1. Зураг төслийн тайлбарыг эхлээд суваглалын төлөвлөлт , дараа нь кабель шугамын төлөвлөлт , 3-рт нь шугамын хамгаалалт 4-рт угсралтын үед анхаарах асуудлууд гэсэн дараалаар тодорхой оруулж байхыг мөрдлөгө болгох .<br><br>Зураг төслийн боловсруулалт " САЙН " үнэлгээтэй<br><br>**2. ХОЛБОО ДОХИОЛОЛ**<br>2018.10.20-нд № 04-07 экспертээр магадлал хийж баталгаажуулсан Өмнөговь аймгийн Манлай суманд барих 15 ортой эмнэлгийн ХД-ийн BDC - 02/2018 зургийг холбоосоор ашиглахаар төлөвлөсөн байна. Төсөлд үндсэндээ |

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
